



**МОНГОЛ УЛСЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 05 дүгээр сарын 17 -ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

**Зөвлөмж батлах тухай**

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.6.4 7.6.7 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 128 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн дүрмийн 2.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1.Жолоочийн хариуцлагыг дээшлүүлэх зарим арга хэмжээний тухай Зөвлөмжийг хавсралтаар баталсугай.

2.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үйл ажиллагааны уялдааг хангуулж, Зөвлөмжийн биелэлтийг хагас, бүтэн жилээр Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Ажлын алба (Ч.Жаргалсайхан)-нд үүрэг болгосугай.

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,  
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ОРЛОГЧ ДАРГА,  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД

Л.ХАЛТАР

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын  
Үндэсний зөвлөлийн 2022 оны 03 дугаар  
тогтоолын хавсралт

**Жолоочийн хариуцлагыг дээшлүүлэх  
зарим арга хэмжээний тухай**

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 128 дугаар тогтоолоор баталсан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн хурлыг 2022 оны 5 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулав.

Үндэсний зөвлөлийн хуралд оролцогч Замын хөдөлгөөний үндэсний зөвлөлийн ажлын алба, Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн алба, Бүртгэл хяналтын төв, Автотээврийн үндэсний төв ТӨҮГ, Монголын автосургууль, курсуудийн нэгдсэн холбооноос “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, анхаарах асуудал”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл, тулгамдаж буй асуудал”, “Жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох үйл ажиллагаа”, “Мэргэшсэн жолооч бэлтгэх, үнэмлэх олгох үйл ажиллагаа”, “Жолооч бэлтгэх байгууллагад тавигдах шаардлага, жолооны багш бэлтгэх үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” илтгэлүүд, төслийг тус тус хэлэлцэв.

Энэхүү хуралдаанаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагааны өнөөгийн байдал, хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагаа, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх талаар тодорхой онолын болон практик үйл ажиллагааны үндэстэй санал, санаачилгуудыг дэвшүүлэн хэлэлцүүлээ.

**Нөхцөл, байдлын тухай**

Сүүлийн 5 жилийн хугацаанд 135617 зам тээврийн осол бүртгэсний 132402 буюу 97,8% нь жолоочийн буруугаас шалтгаалсан бөгөөд ослын улмаас жилд дундажаар 500 хүн амь насаа алдаж, 3537 хүн гэмтэж, 22 тэрбум төгрөгийн бодит хохирол учирч байна.

Судалгаанаас үзэхэд зам тээврийн ослоор нас барсан хүмүүсийн 75% нь орон нутгийн замд, 25% нь Улаанбаатарт байна.

Зам тээврийн осол гаргасан жолоочийн 34 хувь нь 5 жил хүртэл автомашин жолоодсон байгаа нь 100 жолооч тутамын 34 нь, эдгээр жолооч нарын буруугаас жилд 304 хүн амь насаа алдаж байгаа нь замын хөдөлгөөнд оролцогчийг бага наснаас нь бэлтгэх, жолооч бэлтгэх үйл ажиллагааг цогц байдлаар шийдвэрлэх шаардлагатайг харуулж байна.

Хохирол ихтэй, хүний амь нас хохирсон зам тээврийн 8 осол тутмын 1-ийг согтуугаар үйлдэж байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд 413762 жолооч согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож, уг шалтгааны улмаас 1211 хүн амь насаа алдсан байна.

Олон улсын Улаан загалмай, улаан хавирган сар нийгэмлэгийн судалгаагаар зам тээврийн ослоор нас барагсадын 70 хувьд анхны тусламж буруу үзүүлсэн, 20 хувьд эмнэлгийн тусламж үзүүлж чадаагүй, 10 хувь нь аврах боломжгүй гэмтэл байсан гэж үздэг тул анхны тусламж үзүүлэх тогтолцоог улс орон бүр хэрэгжүүлэхийг зөвлөсөн байна.

Мөн хурд хэтрүүлсэн үйлдлийн улмаас гарсан ослын хор уршиг 3-7 дахин нэмэгддэг бөгөөд энэ төрлийн зөрчил жилд 116780 бүртгэгдсэн байна.

2021 онд ШУТИС-ийн МТС, ДХИС-ийн хийсэн "Замын хөдөлгөөнд оролцогдын мэдлэг хандлагын судалгаа"-гаар жолооч бэлтгэх сургалтын чанар хангалтгүй гэж 60%, жолооч нарын дүрмийн мэдлэг шаардлага хангахгүй гэж 73%, замын хөдөлгөөнд оролцогчийн хөдөлгөөнд оролцох соёл муу гэж 82%, жолооч бэлтгэх үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж 86%, хэрэв 90 хувиас дээш мэдлэгтэйг хангалттай гэж үздэг одоогийн журмаар шалгалт авах тохиолдолд хөдөлгөөнд оролцож байгаа жолооч нарын 8% нь л тэнцэхээр байна гэж үзжээ.

Жолооч бэлтгэх байгууллагуудын бэлтгэсэн жолоодох эрхийн шалгалт өгсөн хүмүүсийн 30-40 хувь нь тэнцэж байна.

Зөрчлийн тухай хууль хэрэгжих хугацаанд тухайн жилд бүртгэгдсэн нийт зөрчлийн 90 дээш хувийг цагдаагийн байгууллага харьяалан шалган шийдвэрлэж ирсэн бөгөөд үүнээс нийт зөрчлийн 92.4 хувь нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн зөрчил эзэлж байна.

### **Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн хурлаас**

Үндэсний зөвлөлийн хурлаас 2020 оны 02 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд Швед Улсын Стокгольм хотод зохион байгуулсан "2030 он хүртэлх Дэлхийн цогц бодлогыг хэрэгжүүлэх Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бүх дэлхийн сайд нарын хуралдааны тунхаглал", 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 02 дугаар тогтоолоор баталсан Зөвлөмжийг удирдлага болгон дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөмжилж байна. Үүнд:

#### **Нэг. Жолооч бэлтгэх, мэргэшүүлэх тогтолцоог боловсронгуй болгох талаар**

- 1.1. Жолооч бэлтгэх үйл ажиллагааг боловсронгуй болгох" ажлыг ЗТХЯ, ХЗДХЯ, ХНХЯ, БШУЯ хамтран зохион байгуулж, холбогдох шийдвэрийн төслийг Засгийн газрын хуралдаанд 9 дүгээр сард багтаан танилцуулах
- 1.2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, жолооч бэлтгэхтэй холбоотой олон улсын хэм хэмжээг судлан, шаардлагатай гэрээ хэлэлцээрт нэгдэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжих нөхцөлийг хангах;
- 1.3. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаалаар баталсан "Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалт авах журам" өнөөгийн шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, түүний мөрөөр арга хэмжээ авах;
- 1.4. "Зөрчлийн болон Эрүүгийн хууль"-ийн төсөлд замын хөдөлгөөний аюулгүй байдалд заналхийлсэн аливаа үйлдэл, эс үйлдэлд ногдуулах шийтгэлийг бүрэн тусгаж, сулруулахгүй байх эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- 1.5. Мэргэшсэн жолоочийн сургалт зохион байгуулах эрхийг шаардлага хангасан материаллаг бааз бүхий томоохон үйлдвэр, автотээврийн чиглэлээр мэргэшсэн институци, автотээврийн мэргэжлийн байгууллагуудыг түшиглэн зохион байгуулах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх;

- 1.6. “Хөдөлмөрийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны хамтарсан А/171, А/496 дугаар тушаалаар батлагдсан “Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны хамтарсан А/46,А/09 дугаар тушаалаар батлагдсан “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалт авах журам”, “Жолоодох эрхийн шалгалтын төвийн үйл ажиллагааны журам” болон Монгол Улсын стандарт “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалтын төв. Ерөнхий шаардлага” MNS6584:2016, “Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын байгууллага. Ерөнхий шаардлага” MNS 6585:2016 стандартуудад нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг энэ оны 3 дугаар улиралд багтаан зохион байгуулах;
- 1.7. Сургууль, цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрт хүүхэд, багачуудад бага наснаас нь эхлэн замын хөдөлгөөнд дүрмийн дагуу оролцох хүмүүжил, соёлд суралцуулах сургалтыг тусгах асуудлыг судлан шийдвэрлэх;
- 1.8. Их, дээд сургууль, мэргэжлийн байгууллагыг оролцуулан жолооч бэлтгэх, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд судалгаа хийж, судалгааны дүгнэлтийг үндэслэн сайжруулах ажлыг зохион байгуулах;
- 1.9. Жолооч бэлтгэх, мэргэшүүлэх сургалтанд эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх сургалтыг хөтөлбөрт заасны дагуу зохион байгуулах.:

**Хоёр. Жолоочийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар**

- 2.1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10 зүйлд заасан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын мэдээллийн санг ашиглах асуудлыг дотоод, гадаад төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн ашиглах нөхцлийг 2022 онд багтаан бүрдүүлэх;
- 2.2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан дүрэм, журам, стандартыг батлуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- 2.3. Жолоочийн зөрчлийн бүртгэлд оноо тооцох, зөрчил болон ослын бүртгэлийг даатгалын системтэй уялдуулах;
- 2.4. Замын хөдөлгөөнд оролцогчдын зөрчлийг иргэдийн мэдээллээр “E-Police” аппликейшн ашиглан зөрчилд арга хэмжээ тооцох ажлыг эрчимжүүлэх, Зөрчлийн талаарх мэдээллийг иргэдээс төлбөртэй авах журмыг батлуулах;
- 2.5. Жолоочийн зөрчилд хариуцлага тооцох онооны үзүүлэлтүүдийг чангаруулах;
- 2.6. Хувийн хэвшил, олон нийтийн байгууллагын оролцоог дэмжин жолооч бэлтгэх, мэргэшүүлэх төвүүдийг БНСУ, ЕХУ-д ашиглаж байгаа стандартын дагуу байгуулж, ашиглах асуудлыг шийдвэрлэх.
- 2.7. Олон Улсын Автотээврийн Холбооны жолооч, менежер, тээврийн байгууллагын удирдах ажилтнуудын сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлэх;
- 2.8. Жолоочийн гаргаж буй нийтлэг зөрчил дутагдлыг багасгах чиглэлийн мэдээлэл, сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зохион байгуулах;

- 2.9. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалт авах ажиллагаанд замын хөдөлгөөний болон талбайн жолоодлогын шалгалтыг зохих журамд заасан шаардлагын дагуу авч байхад анхаарах;
- 2.10. Жолооч бэлтгэх, замын хөдөлгөөнд оролцогчийн хариуцлагыг сайжруулах чиглэлээр оролцогч байгууллагуудтай хамтран тодорхой хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх;
- 2.11. Мотоциклийн жолооч, зорчигчдод зориулсан тусгай хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- 2.12. Зам тээврийн ослын эрсдлийг хамгийн ихээр нэмэгдүүлж байгаа мансууруулах бодис, сэтгэл мэдрэлд хүчтэй нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох, тээврийн хэрэгслийн хурдыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэх, хэмгаалах хэрэгсэл хэрэглэхгүй замын хөдөлгөөнд оролцох зөрчлөөс урьдчилан сэргийлэх компани-аас ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;

### **Гурав. Урьдчилан сэргийлэх, судалгаа, сургалт сурталчилгааны ажлын талаар**

- 3.1. 2022 оны 1 дүгээр тогтоолоор баталсан зөвлөмжийн жолоочтой холбоотой заалтуудыг хэрэгжүүлэх;
- 3.2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Салбар зөвлөлийг аймаг тус бүрт яаралтай байгуулж, жолоочийн хариуцлагыг сайжруулах чиглэлээр 2 доошгүй нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулах;
- 3.3. Зам тээврийн ослын нас баралтын 30 хувь нь мотоциклын хэрэглээтэй холбоотой байгааг харгалзан мотоциклын жолоочид чиглэсэн сургалт, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тусгайлан зохион байгуулах.

### **ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ**